

Биологийн төрөл зүйлийн талаар Оюу Толгой ХХК-иас баримтлах стратеги

Стратегийн товч мэдээлэл

Оюу Толгой ХХК-ийн биологийн төрөл зүйлийн талаар дэвшүүлсэн зорилго

Өмнийн говийн бүс нутагт хэрэгжиж буй Оюу Толгой төсөл нь эцсийн дүндээ тухайн бүс нутгийн биологийн төрөл зүйлд эерэг нөлөө үзүүлэхийг эрмэлзэж байна. Рио Тинто компанийн Биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратегитай нийцүүлсэн Оюу Толгой нь өмнийн говийн бүсийн биологийн төрөл зүйлд Цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх зорилготой. Оюу Толгой нь энэхүү зорилгодоо уурхай хаах үед хүрсэн байхаар зорьж байгаа боловч төслийн хугацаанд цэвэр эерэг нөлөөлөлд аль болох боломжтой хугацаанд эрт хүрэх боломжуудыг эрэлхийлэх болно.

Оюу Толгойн биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратеги болон Цэвэр эерэг нөлөөлөл бий болгохтой холбогдох бусад амлалтуудад дараах асуудлуудыг тусгасан. Үүнд:

- **Рио Тинтогийн Биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратеги** Биологийн төрөл зүйлийн хувьд Рио Тинтогийн хэмжээнд дагаж мөрддөг биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратегийг Өмнөговь болон төсөлд тохируулан нийцүүлэх зарчмыг Оюу Толгой баримтална. Рио Тинтогийн энэхүү стратегийн цөм нь Цэвэр эерэг нөлөөллийг бий болгоход чиглэгддэг.
- **Санхүү.** Оюу Толгой төслийн санхүүжилтийн нэлээд хэсэг нь хөгжлийн гурван банкнаас гардаг бөгөөд эдгээр банкууд нь биологийн төрөл зүйлтэй холбоотой гүйцэтгэлийн маш нарийн стандартыг хэрэгжүүлдэг.
- **Газар болон эрдэс баялгийн ашиглалт** Биологийн төрөл зүйлийн менежментийн тэргүүлэх түршлалуудаас нь Рио Тинто/Оюу Толгойг бусад өрсөлдөгчдөөс ялгаатай байх боломжийг бүрдүүлдэг бөгөөд энэ нь Оюу Толгойд нийгмийн зүгээс “үйл ажиллагаагаа эрхлэх зөвшөөрөл” олгох гол бүрэлдэхүүн нь болдог.
- **Монголын Засгийн Газраас Биологийн төрөл зүйлийн талаар баримтлах бодлого** Монгол Улсын бодлого, эрхзүйн актууд нь улс орны байгалийн үнэт зүйлсийн менежмент, хамгаалалт болон эдийн засгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хадгалах хэрэгцээ шаардлагыг тусгасан байдаг.

Биологийн төрөл зүйл үзүүлэх цэвэр эерэг нөлөөллийн талаар дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд Оюу Толгой ХХК нь:

- Төслийн үйл ажиллагаанд өртөх биологийн төрөл зүйлүүд (эн тэргүүн өртөх биологийн төрөл зүйлүүд) болон биологийн эдгээр төрөл зүйлүүдэд нөлөөлөх төсөлтэй хамааралтай аюул заналуудыг тодорхойлох.

- Төсөлтэй холбоотойгоор биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, багасгах, болон нөхөн сэргээлт хийхийн тулд Шатлалын дагуу нөлөөлөл бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх.
- Биологийн төрөл зүйлийн нөхөн хамгааллын стратеги боловсруулах, Өмнийн говийн бүсийн биологийн төрөл зүйлд үзүүлэх төслийн тогтоогдсон үлдэгдэл нөлөөллийг тодорхой хугацааны дараа нөхөн тэнцвэржүүлэх Байгаль хамгаалах нэмэлт арга хэмжээнүүдийг тодорхойлох.
- Биологийн төрөл зүйл, түүний нөхцөл байдалд үзүүлж байгаа үлдэгдэл нөлөөллийн (дарамтын) хэмжээ, зохион байгуулалттай авч буй арга хэмжээний тохиромжтой байдлыг тодорхойлох замаар Оюу Толгойн ЦЭН үзүүлэх зорилгын биелэлтэд хяналт тавих боломж бүхий Мониторинг үнэлгээний хөтөлбөр боловсруулах.
- Төслийн ЦЭН үзүүлэх зорилгын биелэлтийг хянах, нотлох хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулах, турших, хэрэгжүүлэх боломжийг бий болгох.
- Нөлөөллийг бууруулах, нөхөн хамгаалах зорилго, арга хэмжээ, зорилтуудыг Биологийн төрөл зүйлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөөнд (БТЗТ) тодорхой тусгах, уг төлөвлөгөө Оюу Толгойн Байгаль орчны удирдлагын системд нэгтгэх.
- Өмнийн говийн бүс нутаг дахь аж үйлдвэрийн тэргүүлэх компанийн хувьд бүс нутгийн биологийн төрөл зүйлд уул уурхайн бүтээн байгуулалтын ажлын үзүүлэх хуримтлагдсан нөлөөллийг багасгах байр сууриа хадгалж үлдэхэд анхаарах.
- Төслийн бүх үе шатанд биологийн төрөл зүйлийн асуудалтай оролцогч талуудыг оролцуулах, тэдэнтэй зөвлөлдөх, нутгийн иргэд, Монгол Улсын Засгийн Газар, ТББ, судалгаа шинжилгээний байгууллагуудтай бүх түвшинд салбар дамнасан түншлэл бий болгох.
- Оюу Толгойн Биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратегийг Оюу Толгойн байгаль орчин, нийгэм/орон нутгийн стратегиудтай уялдуулах, нэгтгэх.

Биологийн төрөл зүйлийн талаар Оюу Толгой ХХК-иас баримтлах стратеги

Нарийвчилсан стратеги

Энэхүү стратеги нь Оюу Толгой ХХК-ийн төслийн өмнийн говийн бүс нутагт биологийн Цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх арга замыг тодорхойлно. Энэхүү стратеги нь биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг хэмжих, арилгах, тэнцвэржүүлэх, үнэлэх арга замуудын үндэс болно. Түүнчлэн төрийн болон иргэний нийгмийн байгууллага, оролцогч талуудтай биологийн төрөл зүйлийн хүрээнд бий болгох түншлэл харилцаанд баримтлах арга замуудыг тусгасан.

Энэхүү стратегид Цэвэр эерэг нөлөөллийн талаар дэвшүүлсэн зорилгоороо дамжуулан биологийн төрөл зүйлийн менежмент, хамгааллын талаарх амлалтуудыг тусгасан. Цаашлаад бүс нутгийн тогтвортой хөгжлийг бий болгох үүднээс гол оролцогч талуудтай хамтран ажиллахад Рио Тинтогийн биологийн төрөл зүйлийн хэрэглэгдэхүүний багц болон арга туршлагыг хэрэглэх эрмэлзлийн талаар мөн дурдсан.

1. Суурь мэдээлэл

1.1. Рио Тинтогийн Биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратеги

Рио Тинто нь 2004 онд ОУБХН-ийн Дэлхийн Байгаль Хамгаалах Конгресст биологийн төрөл зүйлийн талаар баримтлах тэргүүлэгч стратегийг танилцуулсан бөгөөд үүндээ биологийн төрөл зүйл Цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх компанийн амлалтыг тусгасан юм. Энэхүү бодлогын зорилгыг Рио Тинтогийн гүйцэтгэх захирал Том Албаниз 2008 болон 2010 онд дахин баталгаажуулсан.

Рио Тинтогийн үйл ажиллагаа нь эрдэс баялгийн олборлолт биологийн төрөл зүйлийг хамгаалах үнэт зүйл болон үр нөлөөг зэрэг авч явах боломжтойгоор гэдгийг харуулах замаар Рио Тинто биологийн төрөл зүйлийн эрсдэлийн менежментийг шинээр газар болон байгалийн баялгийг олж авах боломжийг хадгалж улмаар нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Энэ кейс нь хөрөнгө болон даатгал авах, бүтээгдэхүүнээ гаргах зах зээл, хүний нөөц олж авах болон огцом хурдацтай хөгжиж буй дэлхийн болон улс орны бодлогын орон зайд байр сууриа олж авах хэмжээнд өргөжнө. Биологийн төрөл зүйлийн талаар Оюу Толгойгоос баримтлах зарчим нь Рио Тинтогийн дэлхий нийтээр дагаж мөрддөг биологийн төрөл зүйлийн стратегийг Өмнийн говь болон төслийн хүрээнд тохируулан нийцүүлэх явдал юм. Тиймээс Рио Тинтогийн энэхүү стратегийг гол хэсгийг энд иш татан орууллаа.

Рио Тинто нь (2004, 2008) биологийн төрөл зүйлийн талаар дараах байр суурийг илэрхийлжээ.

“Байгаль хамгаалал болон биологийн төрөл зүйлийн хариуцлагатай менежмент нь бизнес болон нийгмийн чухал асуудлууд гэдгийг Рио Тинто хүлээн зөвшөөрдөг. Биологийн төрөл зүйлд цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх нь бидний зорилго”

“Бид:

- *Бидний үйл ажиллагаа нөлөөлсөн биологийн төрөл зүйлийн үнэ цэнийг тодорхойлох*
- *Бизнесийн циклийн явцад бий болох биологийн төрөл зүйлийн эрсдлээс сэргийлэх, бууруулах, арилгах*
- *Өөрсдийн ашиглаж буй газрыг хариуцлагатайгаар ашиглах*
- *Биологийн төрөл зүйлийг хамгаалах боломжуудыг тодорхойлж хэрэгжүүлэх*
- *Биологийн төрөл зүйлтэй холбоотой асуудлуудын менежментэд олон нийт болон бусад холбоотой талуудыг оролцуулахыг эрхэмлэж байна.”*

Рио Тинто (2008) байр суурийн мэдэгдлээ дараах бүлэг суурь зарчмуудаар баяжуулсан байна:

- *Бидний зорилго бол өөрсдийн үйл ажиллагааны сөрөг үр дагавруудыг багасгах, өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгуудад байгаль хамгаалах ажилд хувь нэмрээ оруулах замаар биологийн төрөл зүйлд цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх явдал юм.*
- *Бид устах аюулд өртсөн төрөл зүйл болон эн тэргүүнд анхаарах шаардлагатай хамгааллын бүс нутгийг хамгаалж орон нутаг, үндэсний болон дэлхий нийтийн байгаль хамгаалах санаачлагуудыг дэмжиж ажиллана.*
- *Бид биологийн төрөл зүйлийн талаар гаргах шийдвэр, хэрэгжүүлэх арга хэмжээг олон ургальч үзэл бодлын тэгш байдал, эе эвийг хангахыг зорьж ажиллана.*
- *Бид биологийн төрөл зүйлийн үр дүнд гол оролцогч талуудтай зөвлөлдөх, бүтээлч түншлэл, хамтын ажиллагааны дүнд нэмэгдүүлэхийг зорино.*
- *Бид бизнесийн циклийн явцад биологийн төрөл зүйлийг тодорхойлох, үнэлэх, менежмент хийх ажлыг төлөвлөх, шийдвэр гаргах болон тайлагнах үйл явцын нэгэн хэсэг болгохыг зорино.*
- *Бид биологийн төрөл зүйлийн асуудлуудтай холбоотой туршлага, нөөцийг ашиглах, ингэхдээ шаардлагатай тохиолдолд дотоод болон гадаад чадавхыг бүрдүүлнэ.*
- *Тохирох зөвшилцлийн дагуу бид биологийн төрөл зүйлийн талаарх мэдээлэл, мэдлэгийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, түгээн дэлгэрүүлнэ.*

1.2 Биологийн төрөл зүйлийн асуудлууд Рио Тинтогийн стандартуудад

Биологийн төрөл зүйлийн асуудал нь Рио Тинтогийн мөрдөгдөж байгаа стандартуудын үндсэн бүрэлдэхүүн юм. Биологийн төрөл зүйлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг бизнесийн нэгж гүйцэтгэх нь Газрын ашиглалтын хариуцлагатай менежментийн стандартын (E9) нэг хэсэг юм. Рио Тинтогоос дэлхий даяарх үйл ажиллагаагаа тэдний биологийн төрөл зүйлийн үнэ цэнэ болон эрсдэлээр нь эрэмбэлсэн. Өндөр болон Маш өндөр гэсэн үнэлгээ авсан газрууд нь 2015 он гэхэд Биологийн төрөл зүйлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг 2-р түвшний биологийн төрөл зүйлийн хүрэх түвшний дагуу зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай. Оюу Толгой нь албан ёсоор үнэлэгдээгүй хэдий ч түргэн үнэлгээгээр Рио Тинтогийн биологийн төрөл зүйлтэй хамааралтай үйл ажиллагаануудын дунд нэлээд тэргүүлэх байрыг эзлэх магадлалтай гэж үзэж байна.

1.3 Оюу Толгойн биологийн төрөл зүйлийн стратегийн бизнесийн кейс

Оюу Толгойн биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратеги болон Цэвэр эерэг нөлөөлөл бий болгохтой холбогдох бусад амлалтуудад дараах асуудлуудыг тусгасан. Үүнд:

1.3.1 **Санхүү.** Оюу Толгойн санхүүжилтийн нэлээд хэсэг нь Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Гүйцэтгэлийн стандарт 6¹ болон түүнтэй төстэй хувилбаруудыг хэрэгжүүлдэг хөгжлийн гурван банкнаас гардаг. Энэхүү гүйцэтгэлийн стандарт нь одоо мөрдөгдөж байгаа стандартуудаас биологийн төрөл зүйлтэй холбоотой хамгийн өндөр шаардлагатай нь бөгөөд биологийн төрөл зүйлийн хамгийн тэргүүлэх менежментийг шаарддаг. Үүнд:

- Өөрчлөгдсөн, төрөлхийн болон гол амьдрах орчныг тогтоох.
- Төрөлхийн болон гол амьдрах орчинд үзүүлэх нөлөөллийн нөлөөллийг бууруулах болон биологийн төрөл зүйлийн тэнцвэржилтийг тодорхойлж хэрэгжүүлэх.
- Биологийн төрөл зүйлийн үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэхийн тулд хамааралтай хөндлөнгийн институциудтэй түншлэл бий болгох.
- Биологийн төрөл зүйлийн ашиг алдагдалд мониторинг ба үнэлгээ хийх.

Гол амьдрах орчин гэдэг нь ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 6-д багтсан ойлголт бөгөөд биологийн төрөл зүйлийн өндөр үнэ цэнэтэй газар нутгийг нэрлэх бөгөөд үүнд нэн ховордсон болон ховордсон амьтдын амьд үлдэхэд шаардагдах амьдрах орчин, устаж байгаа болон хязгаарлагдмал тархацтай амьтдад онцгой тохирсон газар нутаг, нүүдлийн амьтдын оршин тогтноход чухал үүрэгтэй газрууд, олноороо цуглардаг амьтдын тодорхой бөөгнөрлийг дэмжих газар нутаг, амьтдын онцгой цугларалт болдог эсвэл эволюцийн гол үйл явцтай холбоотой үгүй бол экосистемийн гол үйлчилгээгээр хангадаг газар нутаг, тухайн орон нутагт нийгэм, эдийн засаг, эсвэл соёлын ач холбогдолтой биологийн төрөл зүйлийг агуулсан газар нутаг багтана.

Оюу Толгой төслийн нөлөө үзүүлж буй газар нутаг бүхэлдээ нэр бүхий биологийн үнэт төрөлд зүйлийн гол амьдрах бүсэд хамаардаг. Тиймээс Гүйцэтгэлийн стандарт 6 нь Оюу Толгой төслөөс дараах асуудлуудад баталгаажуулахыг шаардаж байна. Үүнд:

- Гол амьдрах орчноос гол орчинд амьдрах боломжтой төрөл зүйлийн бий болсон тоо толгой эсвэл тэдгээрийн гүйцэтгэх үүрэг ролийг дэмжих чадварт нь хэмжигдэхүйц сөрөг нөлөөлөл үүсэхгүй байх
- Мэдэгдэж буй нэн ховордсон болон ховордсон ямар ч төрөл зүйлийн тоо толгойд бууралт гарахгүй байх
- Аливаа бага хэмжээний нөлөөллийг тохирох хэмжээнд болон Гүйцэтгэлийн стандарт 6-гийн дагуу бууруулах арга хэмжээг авах.

1.3.2 **Газар болон эрдэс баялгийн ашиглалт:** Монгол Улс нь маш олон тооны уул уурхайн компани идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байгалийн баялгаар баян улс юм.

¹ Оюу Толгой төсөл нь 2006 оны 4-р сарын 30-нд хэвлэгдсэн Олон Улсын Санхүүгийн Корпорацийн (ОУСК) Гүйцэтгэлийн стандарт 6 – Биологийн төрөл зүйлийн хамгаалалт ба байгалийн баялгийн тогтвортой менежмент-тэй нийцэж ажиллах үүрэгтэй.

Нэгдүгээрт Засгийн газраас биологийн төрөл зүйлтэй холбоотой асуудалд хэрхэн хандаж байгаа нь ирээдүйд газар болон эрдэс баялгийн ашиглалт байгаль орны талаарх өмнөх үйл ажиллагаа, үр дүнгээс хамаарахыг илтгэж байна. Тиймээс биологийн төрөл зүйлийн менежментийн тэргүүлэх түршлэгүүд нь Рио Тинто/Оюу Толгойг бусад өрсөлдөгчдөөс ялгаатай байх боломжийг бүрдүүлнэ. Хоёрдугаарт, нутгийн иргэд, иргэний нийгмийнхэн биологийн төрөл зүйл болон биологийн төрөл зүйлтэй хамааралтай байгалийн баялгийг хэрхэн үнэлж цэгнэн тэдгээртэй холбоотой эрхээ хэрхэн эдэлж байгаа нь одоогийн болон ирээдүйн орон нутгийн нийгмийн зүгээс өгөх “үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл” биологийн төрөл зүйл, эко систем, тэдгээртэй холбоотой хүний хүчин зүйлээс үүсэх үйлчилгээний хариуцлагатай менежментээс тодорхой хэмжээнд хамааралтай байхыг илтгэж байна.

- 1.3.3 Монгол Улсын Засгийн Газраас биологийн төрөл зүйлийн талаарх баримтлах бодлого.** Монгол Улс нь байгаль хамгаалах талаар хэрэгжиж буй ихэнх конвенцийг соёрхон баталсан бөгөөд байгаль хамгаалах чиглэлээр дэлхий нийтэд үйл ажиллагаа явуулдаг талуудын дунд дорвитой байр суурийг эзэлдэг. Монгол Улсын Засгийн Газар биологийн төрөл зүйлийн хамгаалах тэр дундаа тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хуулийн хүрээнд хамгаалагдсан тодорхой хэмжээний газар нутагт илүү анхаарал хандуулдаг (13.4%, WDPA 2011). Саяхан Монгол Улсын Засгийн Газраас 2030 гэхэд улсын нийт газар нутгийн 30%-ийг (46.9 сая га) тусгай хамгаалалттай газар болгон хамгаалах эрх зүйн амлалтыг авсан. Засгийн газар эрдэс баялгийн олборлолтоор дамжуулан эдийн засгийн хөгжлийг хангах болон байгалийн үнэт зүйлс баялгийн менежментийг хийж хамгаалах хэрэгцээ шаардлагын тэнцвэрийг хадгалах явдлыг ойлгон ухамсарлаж байгаа. Засгийн газраас энэ хүндрэлтэй асуудлыг зохицуулахын тулд эрх зүйн өөрчлөлтүүдийг хийх арга замыг эрэлхийлж биологийн төрөл зүйлийн нөхөн хамгааллын талаар санаа тавьдаг хэд хэдэн байгууллагатай зөвшилцөл хийж байгаа. Хэдийгээр энэ бүхэн нь эхний шатандаа яваа боловч эдгээр нь яваандаа биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалах үндэсний бодлого болох хувирах боломжтой. Рио Тинто нь дэлхийн хэмжээнд биологийн төрөл зүйлийн нөхөн хамгааллын үйл ажиллагаанд тэргүүлэх үүрэгтэйгээр оролцож ирсэн бөгөөд биологийн төрөл зүйлийн нөхөн хамгааллын талаар дэлхийд тэргүүлэх түршлага болох арга зүйн зөвлөмжийг боловсруулаад байна. Оюу Толгойн биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратеги нь биологийн төрөл зүйлийн менежменттэй холбоотой бодлого, хууль тогтоомжийг сайжруулах бэхжүүлэх хувилбаруудыг судлах боломжийг олгох учраас Монгол Улсын Засгийн Газарт маш чухал кейсийн судалгаа болох юм.

1.4 Биологийн төрөл зүйлийн талаар Оюу Толгойгоос дэвшүүлж буй зорилго

Биологийн төрөл зүйлийн талаар дэвшүүлэх бодлогын зорилгоо Оюу Толгой тодорхойлсон. Энэхүү зорилгыг дор танилцуулж төслийн зүгээс биологийн төрөл зүйлийн менежментийн талаар өгч буй амлалтын орон зайн болон цаг хугацааны цар хүрээг илэрхийлж байна:

Оюу Толгой ХХК-ийн биологийн төрөл зүйлийн талаар дэвшүүлсэн зорилго

Өмнийн говийн бүс нутагт хэрэгжиж буй Оюу Толгой төсөл нь эцсийн дүндээ тухайн бүс нутгийн биологийн төрөл зүйлд эерэг нөлөө үзүүлэхийг эрмэлзэж байна. Рио Тинто компанийн Биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратегитай нийцүүлсэн Оюу Толгой нь өмнийн говийн бүсийн биологийн төрөл зүйлд Цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх зорилготой. Оюу Толгой нь энэхүү зорилгодоо уурхай хаах үед хүрсэн байхаар зорьж байгаа боловч төслийн хугацаанд цэвэр эерэг нөлөөлөлд аль болох боломжтой хугацаанд эрт хүрэх боломжуудыг эрэлхийлэх болно.

2. Стратеги

2.1. Шилдэг үйл ажиллагаа

Биологийн төрөл зүйлийн менежмент дэх шилдэг үйл ажиллагаа нь Рио Тинтогийн бизнесийн бүх нэгжийн хувьд нийтлэг процессыг дагаж мөрддөг. Сүүлийн 10 жилийн хугацаанд Рио Тинто байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг дэлхийн тэргүүлэгч эрдэмтэд, байгууллага, засгийн газар хоорондын агентлагуудтай² биологийн төрөл зүйлийн тэргүүн түршлага болох хэрэглэгдэхүүн, арга зүйг боловсруулах чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж ирсэн.

2.1.1. Биологийн төрөл зүйлүүдийг өртөх байдлаар нь эрэмбэлэх болох менежмент хийхэд Оюу Толгойгоос баримтлах зарчим.

Оюу Толгой нь үйл ажиллагаанд эн тэргүүний хамааралтай биологийн төрөл зүйлийг тодорхойлохын тулд Рио Тинтогийн Биологийн төрөл зүйлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах тогтолцооны дагуу (Зураг 1) биологийн төрөл зүйлийг өртөх байдлаар нь эрэмбэлэхдээ үнэлэмж болон эрсдэлд суурилсан зарчмыг баримталдаг.

Эдгээрт дараах асуудлууд хамаарна. Үүнд:

- **Бүх төрлийн төрөлх амьдрах орчнууд** (шинжээчид болон оролцогч талуудаас байгаль хамгааллын хувьд үнэ цэнэ багатай гэж үзэн БТЗТ-өөс хасахыг зөвшөөрсөн тодорхой амьдрах орчнуудаас бусад).
- **Эн тэргүүн хамгаалах шаардлагатай төрөл зүйл** (дэлхий болон үндэстний хэмжээнд гаргасан жагсаалтад багтсан аюулд өртсөн, тархалт нь хязгаарлагдмал төрөл зүйлүүд, эн тэргүүнд анхаарах шаардлагатай нүүдлийн болон олноороо цуглардаг бүх төрөл зүйлүүд)
- **Эн тэргүүн анхаарах шаардлагатай экосистемийн бүрэлдэхүүн болон газар нутгийн бусад үнэт зүйлс** (үүнд соёлын ач холбогдолтой газар нутаг болон үйл ажиллагаа [жишээлбэл ан агнуур гэх мэт])
- **Байгаль хамгааллын ач холбогдол бүхий газар нутгууд** (үүнд тусгайлан оноосон [жишээлбэл ОУБХН-ийн I-IV түвшний хамгаалалттай газрууд, Рамсарын конвенцид багтсан газар нутгууд, дэлхийн өвийн бүртгэлд багтсан газар нутгууд, үндэсний байгалийн нөөц газрууд, мужийн болон орон нутгийн байгалийн нөөц газрууд] болон тусгайлан оноогоогүй [жишээлбэл Биологийн төрөл зүйлийн гол газар нутгууд, шувуутай холбоотой чухал газар нутгууд гэх мэт] газрууд багтана.

Дээр дурдсан шалгууруудыг баримталбал Оюу Толгой төслийн эн тэргүүнд анхаарах шаардлагатай биологийн төрөл зүйлүүд нь маш олон төрөл байх бөгөөд үүнд ховор болон нэн ховор эмийн ургамал (Оюу Толгой уурхай болон түүний дэд бүтцийн ойр орчимд байгаа нутгийн малчин иргэдийн хувьд чухал); Бага Газрын Чулуу ДЦГ зэрэг хамгаалагдсан газар нутгууд (үндэсний засгийн газарт чухалд үнэ цэнэтэй); Хулан болон Жороо тоодог аюулд өртсөн амьтдын зүйл (үндэсний, бүс нутгийн болон дэлхий нийтийн байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг BirdLife International болон ОУБХН зэрэг байгууллагуудад ач холбогдолтой) багтана.

² Рио Тинтогийн биологийн төрөл зүйлийн хөтөлбөр нь Fauna & Flora International, Conservation International, Birdlife International, Кью дэх Вангийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн болон БХОУН зэрэг дэлхийд тэргүүлэх хэмжээний байгаль хамгаалах ТББ-тай хамтран ажиллаж байна.

2.1.2. Оюу Толгойн шатлалын дагуу нөлөөлөл бууруулах талаар баримтлах зарчим.

Рио Тинтогийн биологийн төрөл зүйлийн менежментийн талаар баримтлах зарчмын дагуу Оюу Толгой нь өөрийн биологийн төрөл зүйлийн эрсдэл болон боломжуудад менежмент хийхдээ шатлалын дагуу нөлөөллийг бууруулах чиглэлийг хэрэгжүүлдэг (Зураг 2). Энэ нь биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа зайлсхийх, багасгах, нөхөн сэргээх арга замаар гэхдээ яг энэ дарааллын дагуу хийхийг эрмэлздэг гэсэн үг юм. Нөлөөллийг бууруулах шат дараалсан боломжууд үгүй болсон эсвэл түүнийг өөрчилж сайжруулсан тохиолдолд ЦЭН-д хүрэхэд үүсч буй үлдэгдэл зайг нөхөхийн тулд тогтоогдсон үлдэгдэл нөлөөллийг хэмжиж биологийн төрөл зүйлийн нөхөн хамгаалал болон байгаль хамгааллын нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай. Шатлалын дагуу нөлөөллийг бууруулах шат дараалал бүрийг буюу өөрөөр хэлбэл зайлсхийх, багасгах, нөхөн сэргээх, нөхөн хамгаалах, болон байгаль хамгааллын нэмэлт арга хэмжээнүүдийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Зайлсхийх:

Зайлсхийх арга хэмжээнүүд нь биологийн төрөл зүйлд нөлөөлөхөөс нь өмнө олборлолтын болон баяжуулалтын үйл ажиллагааг эхлүүлэхээс урьтан өөрчлөх эсвэл зогсоох арга хэмжээнүүд юм. Зайлсхийх арга хэмжээнд хийхээр төлөвлөсөн эсвэл жамаараа явагдах үйл ажиллагаа, арга хэмжээг өөрчлөх шийдвэр багтана.

Багасгах:

Багасгах арга хэмжээнүүд нь аль хэдийн эхэлсэн олборлолтын болон боловсруулах үйл ажиллагааны үр дүнд биологийн төрөл зүйлд учирч болох нөлөөллийн хор хөнөөлийг багасгаж болох арга хэмжээнүүд юм. Эдгээр арга хэмжээнүүд нь биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллийн учрах боломж эсвэл цар хүрээг багасгах боловч тэдгээрээс бүрэн урьдчилан сэргийлж чадахгүй. Зарим арга хэмжээ нь зайлсхийх болон багасгах арга хэмжээний аль алиных нь шинж чанарыг агуулсан байдаг учраас зайлсхийх болон багасгах арга хэмжээг бие биенээс нь ялгах аргагүй байдаг.

Нөхөн сэргээх:

Нөхөн сэргээх арга хэмжээнүүд нь бидний үйл ажиллагааны улмаас сүйтгэгдсэн газар нутгуудад аюулгүй, тогтвортой газрын хэвлийг бий болгох бэлтгэл ажлууд, түүний дараагаар ямар нэгэн тодорхой амьдрах орны хэлбэрийг бий болгох зорилгоор дахин ургамалжуулах ажил хийгдэх арга хэмжээ юм. Засварлах арга хэмжээ нь нөхөн сэргээх арга хэмжээнээс сүйтгэгдэхээс өмнөх амьдрах орчныг аль болох боломжтой хэмжээнд дахин бий болгох зорилготойгоороо ялгаатай. Нөхөн сэргээх болон засварлах арга хэмжээ нь ЦЭН-ийн тоон үзүүлэлтийг хангахын тулд биологийн төрөл зүйлийн хэмжигдэхүйц үнэлэмжийг бий болгох ёстой.

Биологийн төрөл зүйлийн нөхөн хамгаалал

Биологийн төрөл зүйлийн нөхөн хамгаалал нь аливаа төслийн биологийн төрөл зүйлд учрах сэргийлэх боломжгүй үлдэгдэл нөлөөллийг арилгах байгаль хамгааллын арга хэмжээнүүд юм. Нөхөн хамгааллын арга хэмжээг тухайн газар нутагт хийгдэх зайлсхийх болон багасгах арга хэмжээг хэзээ ч орлуулан хийж болохгүй харин үлдэгдэл орон зайг нөхөхөд ашиглах ёстой. Нөхөн хамгааллын арга хэмжээ нь нэг бол амьдрах орчны “сүйтгэлийг өөрчилсөн” (нөхөн хамгаалал нь сүйтгэл нь ямар ч арга хэмжээ авсан урьдчилан сэргийлэх

Оюу Толгой төсөлд нэвтрүүлэх нөхөн сэргээх болон засварлах арга хэмжээнүүд нь Оюу Толгойн Байгаль орчны менежментийн системийн (БОМС) салшгүй хэсэг болох нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд зохицуулагдана.

Төслийн олборлолтын шатанд хэрэгжих биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг Оюу Толгойн Биологийн төрөл зүйлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөөнд (БТЗТ) нарийвчлан тусгана. БТЗТ-д нарийвчлан тусгасан биологийн төрөл зүйлд хамааралтай зорилтууд, хүрэх үр дүнгүүд, арга хэмжээнүүд, хариуцлагууд нь Оюу Толгойн Байгаль орчны менежментийн системд нэгтгэгдэх болно.

Биологийн төрөл зүйлийн талаар авах арга хэмжээний төлөвлөлтийн үйл явц нь биологийн төрөл зүйлд тусгайлан хамаарах асуудлууд болон биологийн төрөл зүйлд учрах нөлөөллийг бууруулах менежментийн тусгайлсан шийдлүүдийг тодорхойлоход чиглэгдсэн байдаг. Цар хүрэнээсээ шалтгаалан биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалах арга хэмжээнүүдийг тусгайлсан үйл явцын дагуу (2.1.2 хэсгийг үзнэ үү) боловсруулагдах бөгөөд нөхөн хамгаалах тодорхой арга хэмжээнүүдийг сүүлд нь БТЗТ-д нэгтгэнэ.

<p>БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТУУД</p> <p>БТЗТ-ийн баг бүрдүүлэх болон оролцогч талуудыг оролцуулах стратеги</p>		
<p>1. Төрөл зүйл/үнэлэмжийг тодорхойлох</p> <p>Үнэлэмж өндөртэй биологийн төрөл зүйлүүд</p>		
<p>2а. Биологийн төрөл зүйлд компаниас үзүүлэх аюул заналыг тодорхойлох</p>	<p>2б. Биологийн төрөл зүйлд гаднаас нөлөөлөх аюул заналыг тодорхойлох</p>	
<p>Элемент 3: Аюул заналыг тодорхойлж эрсдлийн менежмент хийх</p>		
<p>Өндөр үнэлэмжтэй биологийн төрөл зүйлд үнэлгээ шаардлагатай дотоод аюул заналууд</p>	<p>Өндөр үнэлэмжтэй биологийн төрөл зүйлийг нэмэгдүүлэх бүүруулж болох гадаад аюул заналууд</p>	
<p>Төрөлхийн ба тухайн үеийн</p>	<p>3. Аюул заналыг үнэлэх</p> <p>Төрөл зүйлд нөлөөлж болохуйц бараг нөлөө үзүүлэхүйц нөлөөллүүд</p>	<p>4. Боломжуудыг үнэлэх</p> <p>Зайлсхийх боломжгүй нөлөөллийг арилгах арга хэмжээнүүд</p>
<p>5. Нөлөөллийн бүртгэл</p>		
<p>Төрөл зүйлд үзүүлэх онцгой болон өндөр аюул заналууд</p>	<p>Биологийн төрөл зүйлийн боломжит нөхөн хамгааллын арга хэмжээ болон байгаль хамгааллын нэмэлт арга хэмжээнүүд</p> <p>Цэвэр нөлөөллийг тоон хэмжээст оруулах</p>	
<p>Элемент 4: ЭАБОЧ менежментийг сайжруулах төлөвлөлт</p>		
<p>Онцгой/өндөр төрөлхийн эрсдэлүүдийг дунд зэргийн/бага түвшний болгон бууруулахад мониторинг хийх шаардлагууд</p>	<p>6. Хүрэх үр дүнг тодорхойлох</p>	<p>Уурхайн дизайн дээр өөрчлөлт оруулах</p> <p>Компанийн нөлөөний хүрээнд биологийн төрөл зүйлийн нөхцөлд орох өөрчлөлт</p>

Онцгой/өндөр тухайн үеийн аюул заналуудыг бууруулах хүрэх түвшин		Биологийн төрөл зүйлийн хамгааллын ерөнхий нөхцөлд орох өөрчлөлт
Сөрөг ЦЭН-тэй төрлүүдэд чиглэсэн засварлах/нөхөн хамгаалах хүрэх түвшин		Арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд гарч буй ахиц
Байгаль хамгаалах нэмэлт арга хэмжээний хүрэх түвшин		
Элемент 14: Үл мөрдөх, эндэгдэл болон арга хэмжээнүүдийн менежмент	7. Арга хэмжээнүүдийг боловсруулах	9. Хэрэгжүүлэлт ба мониторинг
	Хүрэх түвшинг хангах нарийвчилсан арга хэмжээнүүдийг Компанийн ЭАБОЧ-ын менежментийн тогтолцоонд нэгтгэх	Элемент 13: Хэмжилт ба мониторинг
Элемент 8: Баримтжуулалт ба баримт бичгийн хяналт	8. Баримтжуулах болон харилцаа холбооны төлөвлөгөө	
Элемент 9: Харилцаа холбоо, Зөвлөлдөх, ойлголцол	Оролцогч талууд	Рио Тинтогийн бусад албан хаагчид, захирлууд
	БТЗТ-г хариуцсан байгаль орчны менежер	

Зураг 2: Биологийн төрөл зүйлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө (БТЗТ) боловсруулахад ашиглах алхам алхмаар өгөгдсөн зөвлөмж –дараалсан есөн үе шат бүхий (Эх сурвалж: Рио Тинто, 2010а).

2.1.3. Биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалахад Оюу Толгойгоос баримтлах зарчим.

Оюу Толгой төсөл нь биологийн төрөл зүйлд тогтоогдсон үлдэгдэл нөлөөллийг үзүүлэх болно. Нөхөн хамгаалах болон байгаль хамгаалах нэмэлт арга хэмжээнүүдийг цогцоор нь боловсруулах нь Оюу Толгойд төсөлд хамааралтай үлдэгдэл нөлөөллүүдийг арилгах болон биологийн төрөл зүйлд цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх зорилгодоо хүрэх боломжийг хангах юм.


Оюу Толгой нь Рио Тинтогийн биологийн төрөл зүйлийн түншүүд, бүс нутгийн оролцогч талууд, болон биологийн төрөл зүйлийн чиглэлээр ажилладаг бусад экспертүүдтэй хамтран Оюу Толгой төсөлд зориулсан нөхөн хамгааллын стратегийг боловсруулах болно. Энэ стратеги нь Өмнийн говьд биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалах бүрэн хэмжээний арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэхүү аргыг хэрэглэх шаардлага нь тухайн систем доторх экологийн хил хязгаарын цар хүрээ тэр дундаа эн тэргүүнд анхаарах шаардлагатай биологийн төрөл зүйлийн төрөлхийн экологиос (тухайлбал хулангийн нүүдлийн амьдрал) голлон хамаарч байна.

Оюу Толгой нь биологийн төрөл зүйлийн алдагдал болон эерэг нөлөөг хэмжих болон биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалах арга хэмжээг бий болгоход шаардагдах улс төрийн болон оролцогч талуудын үйл явцтай холбоотой техникийн шинжтэй асуудлуудад хандахдаа энэ талаар Рио Тинтогийн боловсруулсан өргөн хүрээтэй зөвлөмжид суурилах болно. Энэхүү зөвлөмж нь Оюу Толгой төсөлд тохирох биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалах арга хэмжээний загвар болон хэрэгжилтийн хүрээг бий болгоно. (Зураг 3-ыг үзнэ үү).

Үүнтэй зэрэгцэн Рио Тинто нь Говийн бүс нутаг дахь биологийн төрөл зүйлийг хамгаалах ажлын төлөвлөлтөд хувь нэмрээ оруулан Байгаль Хамгаалал (БХ) ТББ-ын Говийн бүсийн Ландшафтын үнэлгээний дизайн хийх замаар боловсруулах төсөлд санхүүгийн дэмжлэг

үзүүлж байна. Энэхүү төслийн зорилго нь “хөгжлийн болон байгаль хамгааллын талаар дэвшүүлсэн зорилгуудын хоорондын зөрчилдөөнийг багасгах, хөгжлийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллөөс зайлсхийх эвсэл нөхөн хамгаалах, Говийн бүсд эцэстээ аль аль тал нь эерэг үр дүнтэй шийдэлд хүрэхэд дэмжлэг үзүүлэх” явдал юм. Энэхүү санаачилга нь Говийн нийт бүс нутаг дахь эн тэргүүний хамгаалах шаардлагатай газар нутгийн мэдээллийн санг байгаль хамгаалах болон хөгжлийн үйл ажиллагааны хоорондын зөрчилдөөнийг тодорхойлох, ландшафтын түвшинд шат дараалан нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар бий болгох юм. Оюу Толгой ХХК нь БХ-тай нарийн хамтран ажиллаж Оюу Толгойд байгаа биологийн төрөл зүйлтэй хамааралтай мэдээлэл БХ-ын гүйцэтгэж буй ландшафтын үнэлгээний үйл явцад ашиглагдах, түүнчлэн БХ-ын төслийн үр дүн Оюу Толгойн биологийн төрөл зүйлийн хөтөлбөрт цаг хугацаа алдалгүйгээр мэдээллээр хангах боломжийг баталгаажуулна.

Биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалах талаар Оюу Толгойн баримтлах зарчим нь уян хатан байна. Өөрөөр хэлбэл экологийн холбогдолтой шинэ эсвэл шинэчлэгдсэн мэдээлэл болон оролцогч талуудын хүлээлтэд гарах өөрчлөлтийг тусгах шаардлагатай тохиолдолд түүнд нийцүүлнэ. Ялангуяа БХ-ын дизайн хийх замаар хөгжүүлэх хөтөлбөрийн үр дүн Өмнийн говьд биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалах үйл ажиллагаанд шинэ хандлага, боломжуудыг бий болгох магадлал өндөр байна. БХ-тай илүү ойр ажилласнаар Оюу Толгой нь дизайн хийх замаар хөгжүүлэх хөтөлбөрийн үр дүн Оюу Толгойн биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалахад баримтлах зарчимд тусгах нэгтгэх явдлыг хангах болно.



Зураг 3. Биологийн төрөл зүйлийг нөхөн хамгаалах арга хэмжээг боловсруулах үе шатууд. Үе шатуудыг цэнхэр өнгийн дэвсгэртэй хайрцагт харууллаа. Үүнд: Нөхөн хамгааллын цар хүрээг тодорхойлох, Нөхөн хамгааллын судалгаа хийх, ЦЭН-ийн бүртгэл хийх, эцсийн шийдвэр гарах ба сонголт хийгдэх үе шатууд багтана (Эх Сурвалж: Рио Тинто, 2010б).

2.1.4. Мониторинг, үнэлгээний талаар Оюу Толгойгоос баримтлах зарчим.

Сайтар боловсруулсан, зардал-үр ашгийн харьцаа сайтай мониторинг, үнэлгээний хөтөлбөр нь Оюу Толгойн биологийн төрөл зүйлийн менежментийн талаар баримтлах уян хатан зарчмыг мэдээллээр хангахад чухал үүрэгтэй. Цаашлаад энэ нь дотоод болон гадаад оролцогч талууддаа Цэвэр эерэг нөлөөллийн талаар дэвшүүлсэн зорилгуудад гарч буй ахицаа харуулах илэрхийлэх Оюу Толгойн чадварыг сууриар нь дэмжинэ (дор өгөгдсөн 2.1.5 хэсгийг үзнэ үү).

Оюу Толгой саяхан хэвлэгдсэн Рио Тинтогийн арга зүйн зөвлөмжүүд, Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Гүйцэтгэлийн стандарт 6 болон дотоод, гадаадын экспертүүдээс (академик, төрийн болон төрийн бус байгууллагууд) мониторинг ба үнэлгээний үр дүнтэй хөтөлбөрийг боловсруулах талаар өгсөн зөвлөмжүүдэд анхаарлаа хандуулна. Оюу Толгой нь дараах асуудлуудыг хэмжих болон үнэлэх тохирох арга зүйг сонгох болно. Үүнд:

- Биологийн төрөл зүйл үзүүлэх төслөөс хамааралтай тогтоогдсон үлдэгдэл нөлөөлөл
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээний зохицол болон үр ашиг
- Нөхөн хамгаалах арга хэмжээний зохицол болон үр ашиг.

Өмнийн говийн биологийн төрөл зүйлийн нөхцөл байдал, төслийн үйл ажиллагаанаас биологийн төрөл зүйлд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаарх Оюу Толгойн ойлголт 2011 онд мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн нь биологийн төрөл зүйлийг үнэлэх түргэвчилсэн үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэнтэй нэлээд хэмжээгээр холбоотой. Биологийн төрөл зүйлийн талаарх бидний ойлголтыг өргөжүүлснээс гадна энэхүү хөтөлбөр нь анхаарах шаардлагатай мэдлэгийн хэд хэдэн орон зайг тодорхойлж өгсөн бөгөөд тэгснээрээ төслөөс үзүүлэх нөлөөлөл, нөлөөллийг бууруулах боломжит хувилбарууд, бүс нутгийн хэмжээнд бэлэн байгаа байгаль хамгаалах боломжууд/нөхөн хамгаалах хувилбаруудыг бүрэн ойлгох боломжийг бий болгож байна. Дор дурдсан мэдлэгийн эдгээр орон зай нь 1.1 хэсэгт тусгасан биологийн төрөл зүйлийн талаар баримтлах Рио Тинтогийн мөрдөх зарчмуудтай уялдан мониторинг ба үнэлгээний тэргүүлэх чиглэл болох болно.

Оюу Толгойн хувьд мониторинг ба үнэлгээний тэргүүлэх чиглэлүүд болгон тодорхойлсон биологийн төрөл зүйлийн талаарх мэдлэгийн орон зай нь:

- Хулан болон бусад нүүдлийн туурайтан амьтдын шилжилт хөдөлгөөн.
- Тээврийн хонгилуудтай холбоотойгоор хулангийн амьдралын хэв маяг.
- Цахилгаан дамжуулах шугам зэрэг Жороо тоодогт саад учруулж буй зам болон бусад дэд бүтэц.
- Эн тэргүүн анхаарах шаардлагатай биологийн төрөл зүйлийн бэлчээрийн түвшинд үзүүлэх нөлөөллүүд.
- Бэлчээр болон биологийн төрөл зүйлд үзүүлэх гүний усны түвшний өөрчлөлтийн нөлөөлөл.
- Заг түүх тасралтгүй түвшин.

Шаардлагатай тохиолдолд Оюу Толгой Өмнийн говийн биологийн төрөл зүйлтэй хамааралтай бусад оролцогч талуудтай мониторинг ба үнэлгээний хөтөлбөрийн орон зай цаг хугацааны цар хүрээ болон зардал үр ашгийн зөв зохицлыг хангах үүднээс хамтран ажиллах үялдуулах боломжуудыг эрэлхийлэх болно.

2.1.5. Цэвэр эерэг нөлөөллийг баталгаажуулахад Оюу Толгойгоос баримтлах зарчим
Рио Тинтогийн хүсэлтээр мөн тэдний хамтын ажиллагааны дүнд Рио Тинтогийн ЦЭН-ийн зорилтуудын талаарх амлалтын биелэлтийг магадлах бие даасан үйл явцыг боловсруулах, турших, хэрэгжүүлэх Цэвэр эерэг нөлөөллийн протокол ба хянах багийг (ЦЭНП&ХБ) бүрдүүлсэн.

Өмнийн говийн биологийн төрөл зүйлд цэвэр эерэг нөлөөллийг үзүүлэхийн төлөө ажиллаж буй төслийн хувьд Оюу Толгой нь:

- ЦЭН-ийг баталгаажуулах ЦЭНП&ХБ-ийн хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулж турших ажлыг тохирох нөхцөлд нь нөхцөл бололцоогоор хангаж, хувь нэмрээ оруулна.
- Ялангуяа Оюу Толгойн ЦЭН-ийг бий болгоход гарч буй ахиц зөв гольдрилдоо байгаа эсэхийг хянах, эцэстээ Оюу Толгой өөрийн дэвшүүлсэн ЦЭН-ийн зорилгодоо хүрсэн эсэхийг магадлахын тулд Оюу Толгой төслийн хугацаанд эдгээр хэрэглэгдэхүүнүүдийг бие даан хэрэгжүүлэх (бүрэн боловсруулсны дараа) ажилд оролцоно.

2.1.6. Судалгаа шинжилгээний ажил болон байгаль орчны боловсролын талаар Оюу Толгойгоос баримтлах зарчим.

Тохирох нөхцөлд нь Оюу Толгой Өмнийн говийн бүс нутаг дахь биологийн төрөл зүйлийн болон байгаль орчны менежментийн талаарх ерөнхий ойлголтод хувь нэмрээ оруулах судалгаа шинжилгээний ажлуудыг дэмжинэ. Оюу Толгой биологийн төрөл зүйлийн талаар судалгаа, шинжилгээний ажил хийгдэх боломжийг бий болгох талаар эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагааны харилцаа холбоог бий болгон эдгээр байгууллага болон өөрийн Биологийн төрөл зүйлийн судалгааны баг хоорондын мэдлэгийн солилцоог дэмжих талаар ажиллана.

Оюу Толгой өөрийн ажиллагсад, гэрээт байгууллага, хүмүүсийн байгаль орчны боловсрол нь төслөөс биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний салшгүй хэсэг гэж үздэг бөгөөд уурхайд явуулах байгаль орчны талаарх сургалт болон боловсролын төрөл бүрийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж тэдгээрийг байнга сайжруулж байх болно. Түүнчлэн Оюу Толгой нь орон нутгийнханд чиглэсэн байгаль орчны чиглэлийн сургалт, боловсрол олж авах боломжуудаар хангах замаар тухайн бүс нутаг дахь биологийн төрөл зүйлийг хамгаалах асуудлуудыг талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийг зорьж ажиллана.

2.2. ЦЭН-д хүрэхэд тохиолдох эрсдлүүд

2.2.1. Бүс нутгийн манлайлал.

Өмнийн говийн биологийн төрөл зүйлийн менежмент нь тухайн бүс нутаг дахь хамгаалах шаардлагатай тодорхой төрөл зүйлийн хамрах газар нутгийн хэмжээ болон нүүдлийн хэв маягаас шалтгаалан бүс нутгийн хэмжээнд байх зарчмыг баримтлахыг шаардаж байна. Тиймээс тус бүс нутагт хөгжлийн үйл ажиллагаа явуулж буй бусад байгууллагууд (сайн дураар болон эрх зүйн хүрээнд) Оюу Толгойн баримталж буй

өндөр стандарттай нийцэж ажиллахгүй бол биологийн төрөл зүйлийн зүй зохистой менежмент хийх хүчин чармайлтуудын үнэ цэнэ хязгаарлагдмал хэмжээнд очих болно. Өөрөөр хэлбэл Өмнийн говьд уул уурхайн үйл ажиллагаанаас үзүүлэх нийт нөлөөлөл өндөр байна гэж тооцоолж байгаа бөгөөд (Уолтон, 2010) тиймээс биологийн төрөл зүйлийн менежмент хийх салбарын болон бүс нутгийн тэргүүлэгч байх нь Оюу Толгойн эрх ашигт нийцнэ.

Оюу Толгой нь Монгол Улсад хэрэгжиж байгаа хөгжлийн хамгийн том төсөл бөгөөд тус улсын эдийн засгийн хөгжилд голлох үүрэгтэй хэмээн тооцогддог. Энэхүү манлайлал нь Оюу Толгойд Монгол Улсад өсөн нэмэгдэж буй уул уурхайн салбарт салбарын тэргүүлэгч, Өмнийн говийн бүс нутагт бүс нутгийн тэргүүлэгч байх боломжийг олгож байна. Тогтвортой хөгжил бол Рио Тинтогийн төсөл боловсруулах бодлого болон аж үйлдвэрийн өсөлтийн загварын тулгын чулуу нь байдаг. Байгаль орчны тогтвортой байдал үүний нэг бүрэлдэхүүн болдог.

Оюу Толгой биологийн төрөл зүйлийн менежментийг хийх болон бүс нутгийн тогтвортой хөгжлийг авч явах чиглэлд салбарын болон бүс нутгийн манлайлагч байх талаараа мэдэгдэхүйц алхмуудыг хийгээд байна. Оюу толгой Энержи Ресурс ХХК-тай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан бөгөөд энэ нь экологийн судалгаа, шинжилгээ болон мониторингийн чиглэлээр хамтын ажиллах нөхцөлийг бүрдүүлж биологийн төрөл зүйлийн менежментэд нэгдмэл зарчмаар хандах явдлыг хөхүүлэн дэмжинэ. Цаашлаад Оюу Толгой орон нутгийн болон бүс нутгийн төлөвлөлт болон дэд бүтцийн чиглэлээр санаачлагуудыг боловсруулж хэрэгжүүлнэ. Эдгээр санаачлагууд нь сум болон аймгийн удирдлагуудад дэд бүтцийн хөгжил, газрын ашиглалт, биологийн төрөл зүйлийн хамгаалалт зэрэг байгалийн баялгийг хамгаалахтай холбогдсон зохицуулалтуудыг хийхэд нь туслах сургалтын болон нөөц, эх сурвалжуудыг бий болгоно.

Оюу Толгой нь ирээдүйд бүс нутгийн биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг боловсруулах ажлыг дэмжихээр төлөвлөж байна. Үүнд засгийн газар эсвэл өөр бусад гуравдагч этгээд оролцогч талуудын консорциумыг тэргүүлэн хамтдаа бүс нутгийн хэмжээний дэд бүтцийн загварыг бий болгон, зохицуулж, хэмжих ажил багтана. Жишээлбэл экспорт хийх замууд, төмөр зам, гүний усны ашиглалт, цахилгаан үүсгэх болон дамжуулах систем гэх мэт. Өнөөг хүртэл үүсээд байгаа хамгийн чухал асуудал бол хулангийн дэлхийн хэмжээний нөөц болсон амьдрах орчноор дайрч гарч буй Оюу Толгойн экспортын зам/үндэсний замын сүлжээнээс үзүүлэх боломжит урт хугацааны нөлөөлөл юм.

2.2.2. Стратегийн түншлэл.

Биологийн төрөл зүйл нь нийгмийн хэмжээний асуудал учраас биологийн төрөл зүйлийг тойрсон шийдвэр гаргах үйл явцад оролцогч талуудыг оролцуулах нь стратегийн чухал агуулга юм. Засгийн газар, ТББ-ууд, сургалтын байгууллагууд болон бусад байгууллагуудтай салбар дамнасан түншлэл бий болгох явдлыг Оюу Толгойн биологийн төрөл зүйлийн хөтөлбөрийг боловсруулах болон хэрэгжүүлэх ажлын үндсэн хэсэг гэж үздэг. Орон нутгийн, үндэсний болон олон улсын хэмжээний оролцогч талуудтай зөвлөлдөх нь компанийн биологийн төрөл зүйлд чиглэсэн хөтөлбөрийг дэмжих, өөриймсөг хандах явдалд хүргэх чухал алхам юм.

Монгол Улсын хувьд байгаль орчноороо бахархах явдал хүчтэй тогтсон байдаг. Өмнийн говийн бүс нутаг нь байгаль орчноосоо эдийн засаг болон соёлын тогтвортой дэмжлэгийг авдаг. Учир нь хүн ам болон орлогын эх үүсвэр бий болгох үйл

ажиллагааны дийлэнх нь байгалийн баялагтай харилцах үндсэн харилцаанд суурилсан байдаг. Энэ дундаас мал маллах явдал онцгойрон ялгардаг. Оюу Толгой төслийн хувьд өмнө нь оршин байсан газар ашиглалтын энэхүү хэлбэртэй бүрэн огтлолцож байна. Оюу Толгойн биологийн төрөл зүйлийн талаарх болон олон нийтэд хандсан стратегитай уялдуулан нийгмийн болон экологийн судалгааг энэхүү систем болон түүний харилцан хамаарлыг илүү ойлгохын тулд зохион байгуулах шаардлагатай.